



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 03

Сүхбаатар

Комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 66 дугаар зүйлийн 66.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйлийн 3.5.3, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам"-ын 3.1, 3.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хушаат, Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар, Номгон тосгоны сургуулийн захирал, Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Сонгон шалгаруулах комиссын дарга:

Д.Ёндонжамц

-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Нарийн бичгийн дарга:

Б.Ариундэлгэр

-Хүний нөөцийн мэргэжилтэн, Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

А.Эрдэнэгэрэл

-Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Ч.Алтантуяа


-Боловсрол, соёл урлагийн газрын Монгол, хэл, бичиг, уран зохиолын боловсролын мэргэжилтэн

Ц.Золжаргал

-Боловсрол, соёл урлагийн газрын Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг зарласан хугацаанд зохих журмын дагуу зохион байгуулан дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрийг холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Ариундэлгэр/-д даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА

C:\users\albanbichig2020\tushaalA4.docx

430800011